



“БҮРЭНФИНАНС ББСБ” ХХК-ийн  
МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

БАТАЛГААЖИЛТ			
Үйлдэл	Нэр /Албан тушаал/	Гарын үсэг / Тамга	Нууцлалын зэрэг
Боловсруулсан:	Б.Баясгалан /ЭУГ-ын захирал/		
Хянасан:	Н.Амарбаясгалан /Гүйцэтгэх захирал/		<input type="checkbox"/> Нууц
БАТАЛСАН:	“БҮРЭНФИНАНС ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Амарбаясгалан		<input type="checkbox"/> Хязгаарлагдмал <input checked="" type="checkbox"/> Албан хэрэгцээнд <input type="checkbox"/> Олон нийтэд нээлттэй
ОГНОО:			2025-04-29

Хамрах хүрээ: "Бүрэнфинанс ББСБ" ХХК-ийн үйл ажиллагаа	Хариуцах эзэн: Эрсдэлийн удирдлагын газар
Хувийг хадгалах: Баримт бичиг хариуцсан ажилтан	Танилцах: "Бүрэнфинанс ББСБ" ХХК-ийн нийт ажилтнууд
Хэрэгжиж эхлэх хугацаа: 2025-04-30	Хуудасны тоо: 17
Журмын дугаар: БФ - 011	Хувилбар: V-2.0

Өөрчлөлтийн түүх

д/д	Хувилбар	Өөрчлөлт хийгдсэн огноо	Өөрчлөлтийн агуулга
1	V-1.0	2020-12-30	Хувь нийлүүлэгчийн 20/020 тоот шийдвэр, ББСБ-ын дотоод хэрэгцээнд зориулан боловсруулсан.
2	V-2.0	2025-04-29	Гүйцэтгэх захирлын ГЗ25/061 тоот тушаалын хавсралт4-ийн дагуу батлагдсан. ISO27001:2022 стандартыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинэчилэв.
3			
4			

<b>№ ТОВЧ АГУУЛГА</b>	<b>Хуудас</b>
1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	3
2. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР .....	3
3. ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ ТОГТООХ .....	5
4. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	5
5. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ НАРИЙВЧИЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА ..	7
6. УЛС ТӨРД НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ .....	8
7. ТУСГАЙ ХЯНАЛТ .....	9
8. МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГ .....	9
9. ХАРИЛЦАГЧИЙН ГҮЙЛГЭЭГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ .....	10
10. ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ .....	10
11. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ .....	11
12. ХАРИЛЦАГЧИЙН БАРИМТ МАТЕРИАЛЫН ХАДГАЛАЛТ .....	12
13. ХУУЛЬ ТОГТООМЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ҮҮРЭГ .....	12
14. ХЯНАЛТ ХАРИУЦЛАГА .....	14

#### НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

1. ББСБ - “Бүрэн финанс ББСБ”
2. МБ - “Монгол банк”
3. СМА - Монгол банкны “Санхүүгийн мэдээллийн алба”
4. СЗХ - “Санхүүгийн зохицуулах хороо”
5. ТУЗ - “Төлөөлөн удирдах зөвлөл”
6. ГЗ - “Гүйцэтгэх захирал”
7. ЭУГ - “Эрсдэлийн удирдлагын газар”
8. КХА - “Комплаенс хариуцсан ажилтан”
10. ҮОХЗДТ - “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризм”
11. МУТС - “Мөнгө угаах терроризмийг санхүүжүүлэх”
12. ХМТ - “Харилцагчийг таньж мэдэх”
13. БМГТ - “Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан”
14. СГТ - “Сэжигтэй гүйлгээний тайлан”
15. УТНБЭ - “Улс төрийн нөлөө бүхий этгээд”

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “Бүрэн Финанс ББСБ” /цаашид “ББСБ” гэх/-ын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам /цаашид “Журам” гэх/-ын зорилго нь Монгол Улсын “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах, мөнгө угаах, терроризм /үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх/-ыг санхүүжүүлэх аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журам нь Монгол Улсын “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль”, “Санхүүгийн зохицуулах хороо” /СЗХ/ болон бусад эрх бүхий байгууллагаас Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх /цаашид МУТС гэх/-тэй тэмцэх чиглэлээр гаргасан баримт бичигт нийцсэн байна.
- 1.3. ББСБ нь МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална. Үүнд:
  - 1.3.1. МУТС үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй аливаа сэжигтэй үйлдлээс ангид байх;
  - 1.3.2. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, харилцагчийн данс болон гүйлгээнд хяналт тавих;
  - 1.3.3. НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн хориг арга хэмжээний жагсаалт болон Засгийн газрын гаргасан дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд /цаашид “жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд” гэх/ ББСБ-ын аливаа ажил, үйлчилгээг үзүүлэхгүй байх.
- 1.4. МУТС-ээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагааг ББСБ-ын хүрээнд Комплаенс хариуцсан ажилтан /цаашид КХА гэх/ болон Эрсдэлийн удирдлагын газар /цаашид ЭУГ гэх/ хариуцан, зохион байгуулж ажиллана.
- 1.5. Гүйцэтгэх захирлын зүгээс МУТС-ээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/-д үр дүнг тайлагнана.
- 1.6. Энэхүү журам нь ББСБ-ын бүхий л үйл ажиллагаанд хамаарах бөгөөд нийт ажилтнууд нь журмын хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

## ХОЁР. НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР

- 2.1. “Мөнгө угаах” гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг;
- 2.2. “Терроризм” гэж улс төр, шашин, үзэл суртал, эдгээртэй адилтгах бусад зорилгодоо хүрэхийн тулд төрийн байгуулал, нийгэм, эсхүл түүний тодорхой хэсэгт нөлөөлөн айдас автуулахаар хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэх, гамшгийн

- нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг;
- 2.3. “Терроризмыг санхүүжүүлэх” гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг;
  - 2.4. “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Монгол Улсын олон Улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологи болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зорилгоор хоёрдмол зориулалттай бараа бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, олж авах тээвэрлэх, экспортлох, шилжүүлэх, хуримтлуулах, худалдах, худалдан авах, ашиглахад бүрэн, эсхүл хэсэгчилсэн санхүүгийн дэмжлэг, үйлчилгээг үзүүлэхийг;
  - 2.5. “Бэлэн мөнгөний гүйлгээ” гэж үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, түүнчлэн олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг чек, вексель, үнэт цаас ашиглан хийсэн гүйлгээг;
  - 2.6. “Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан” /цаашид “БМГТ” гэх/ гэж бэлэн мөнгөний гүйлгээний тухай мэдээллийг агуулсан, батлагдсан маягтын дагуу Монгол банкны Санхүүгийн мэдээллийн алба /цаашид “СМА” гэх/-нд хүргүүлэх баримт бичгийг;
  - 2.7. “Сэжигтэй гүйлгээ” гэж мөнгөний гарал үүсэл, эцсийн хүлээн авагч нь тодорхой бус эсхүл МУТС-тэй тэмцэх санхүүгийн хяналтын механизм бүрдүүлээгүй улсаар дамжуулан хийсэн, түүнчлэн МУТС-тэй холбоотой гэж үзэж байгаа гүйлгээг;
  - 2.8. “Сэжигтэй гүйлгээний тайлан” гэж /цаашид СГТ гэх/ гэж мөнгөний гарал үүсэл болон төлбөр хүлээн авагчийн нэр хаяг тодорхой бус түүнчлэн Мөнгө угаах, терроризм /үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх/-ыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд холбогдсон байж болзошгүй гүйлгээ, түүнийг хийж гүйцэтгэсэн этгээдийн тухай мэдээллийг агуулсан Монгол банкнаас баталсан маягтын дагуу банкнаас СМА-д ирүүлэх баримт бичгийг;
  - 2.9. “Гүйлгээг түдгэлзүүлэх” гэж сэжигтэй гүйлгээний талаар шалгах зорилгоор СМА-аас гаргасан шийдвэрийн дагуу тухайн гүйлгээг түр зогсоохыг;
  - 2.10. “Харилцагчийн талаарх мэдээллийг шалгах” гэж харилцагчийг таньж мэдэх зорилгоор Монгол Улсын хууль тогтоомжоор хориглоогүй харилцагчийн тухай мэдээллийг харилцагчаас гаргуулж авах, тухайн мэдээллийн үнэн зөвийг тогтоох зорилгоор албан ёсны бичиг баримт, төрийн байгууллагын мэдээллийн сан болон мэдээллийн бусад эх үүсвэрийг ашиглахыг;
  - 2.11. “Хориг арга хэмжээ” гэж Нэгдсэн Үндэсний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан тогтоолын дагуу үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой хориг арга хэмжээг;
  - 2.12. “Хориг арга хэмжээний жагсаалт” гэж НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолоор “Террорист этгээд” гэж зарлагдсан, АНУ, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Европын Холбоо, бусад улс, олон улсын эрх бүхий байгууллага, түүнчлэн Корреспондент харилцаатай банк, өөрийн банкнаас гүйлгээ хийхийг хориглосон улс, банк бусад этгээдийг багтаасан жагсаалтыг;
  - 2.13. “Дотоодын жагсаалт” гэж үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотойгоор терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын саналыг

- үндэслэн Засгийн газраас баталсан хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг;
- 2.14. Улс төрд нөлөө бүхий этгээд /цаашид УТНБЭ гэх/ гэж нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг;
- 2.15. “Комплаенс хариуцсан ажилтан” гэж ББСБ-ын Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон, МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаанд хяналт тавьж, хуулийн дагуу БМГТ болон СГТ-г Монгол банкны СМА-д илгээх, ББСБ-ыг төлөөлж СМА-тай харилцах эрх бүхий ажилтныг;
- 2.16. “ХТМ үүрэг бүхий ажилтан” гэж санхүүгийн гүйлгээнд шууд оролцож, харилцагчийг таньж мэдэх үүрэг бүхий зээлийн эдийн засагч, ерөнхий нягтлан бодогч, салбар хариуцсан нягтлан бодогч нарыг тус тус хэлнэ.

### ГУРАВ. ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ ТОГТООХ

- 3.1. ББСБ нь эцсийн өмчлөгчийг дараах дарааллаар шалгаж тогтооно:
- 3.1.1. хувьцааны дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хүнийг;
- 3.1.2. энэхүү журмын 3.1.1-д заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдаж байгаа, эсхүл өөрийн эрхээ бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хүнийг;
- 3.1.3. энэхүү журмын 3.1.1, 3.1.2-т заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэгч хүнийг.
- 3.2. Шаардлагатай тохиолдолд КХА болон ЭУГ-т мэдэгдэж, эцсийн өмчлөгчийг шалгаж тогтоох нарийвчилсан арга хэмжээ хэрэгжүүлнэ.
- 3.3. Эцсийн өмчлөгчийг шалгаж тогтоох талаар авч хэрэгжүүлэх нарийвчилсан үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

### ДӨРӨВ. “ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ” ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 4.1. ББСБ нь “МУТС-тэй тэмцэх тухай хууль”-ийн 5.1-д заасны дагуу “Харилцагчийг таньж мэдэх /цаашид “ХТМ” гэх/” үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор харилцагчийг тодорхойлж, харилцагчийн мэдээллийг баталгаажуулан, шаардлагатай арга хэмжээг авна.
- 4.2. ББСБ-ын дараах ажилтнууд /цаашид ХТМ үүрэг бүхий ажилтан гэх/ нь ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлж, харилцагчийн болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг бизнесийн харилцааны туршид цуглуулж хадгална. Үүнд:
- 4.2.1. зээлийн эдийн засагч;
- 4.2.2. ерөнхий нягтлан бодогч;
- 4.2.3. салбарын хариуцсан нягтлан бодогч.
- 4.3. Дараах тохиолдлуудад ХТМ үүрэг бүхий ажилтнууд нь албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ мэдээллийн эх үүсвэр, нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан

- харилцагчийг таньж мэдэх үүрэгтэй. Үүнд:
- 4.3.1. санхүүгийн үйлчилгээ болон бизнесийн харилцаа үүсгэхийн өмнө;
  - 4.3.2. санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээд тохиолдлын чанартай 20 сая төгрөг /*түүнтэй тэмцэх хэмжээний гадаад валют*/, түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө;
  - 4.3.3. харилцагчийн 24 цагийн дотор хийсэн, хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний нийт дүн нь 20 сая төгрөг /*түүнтэй тэмцэх хэмжээний гадаад валют*/, түүнээс дээш дүнтэй гүйлгээ хийхийн өмнө;
  - 4.3.4. харилцагчийн талаар өмнө нь авсан мэдээллийн үнэн зөв эсэхэд эргэлзсэн тохиолдолд;
  - 4.3.5. тухайн харилцагчийг эсхүл түүний гүйлгээг МУТС үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэсэн аливаа тохиолдолд.
- 4.4. ХТМ үүрэг бүхий ажилтан нь энэ журмын 4.3–т заасан тохиолдлуудад харилцагчийг таньж мэдэхийн тулд баримт бичгийн эх хувь болон бусад мэдээллүүдийг гаргуулан авч, шалгах бүрэн эрхтэй. Үүнд:
- 4.4.1. Харилцагч иргэн бол
    - 4.4.1.1. ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн огноо;
    - 4.4.1.2. Иргэний үнэмлэх, эсхүл гадаад паспортын хуулбар (*хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээ хийнэ*);
    - 4.4.1.3. иргэний үнэмлэхийн дугаар, регистрийн дугаар;
    - 4.4.1.4. оршин суугаа хаяг, холбоо барих утасны дугаар;
    - 4.4.1.5. эрхэлж буй ажил, ажлын газрын нэр хаяг, түүнтэй адилтгах бичиг бусад баримт бичиг;
    - 4.4.1.6. Баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар.
  - 4.4.2. Харилцагч хуулийн этгээд бол
    - 4.4.2.1. хуулийн этгээдийн албан ёсны нэр, оршин байх газрын хаяг, харилцах утасны дугаар;
    - 4.4.2.2. улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, тусгай үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээний хуулбар;
    - 4.4.2.3. улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /*хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээ хийнэ*/;
    - 4.4.2.4. удирдлагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
    - 4.4.2.5. төлөөлөх эрх бүхий этгээдийн нэр, хаяг, албан тушаалын талаар мэдээллийг бүрэн авч программд оруулах;
    - 4.4.2.6. баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар.
  - 4.4.3. Эцсийн өмчлөгчийн нэрийн өмнөөс данс нээж, гүйлгээ хийж байгаа эсэхийг мэдэх ойлгох зорилгоор тухайн бизнесийн харилцааны зорилго, гүйлгээний утга, эцсийн хүлээн авагчийн тухай мэдээллийг тодруулах;
  - 4.4.4. Харилцагч нь хуулийн этгээд бол түүний эцсийн өмчлөгчийн овог, эцэг/эхийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, эцсийн өмчлөгчийн талаар болон харилцагчийн

- өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхтэй холбоотой боломжит бүх арга хэмжээг авах;
- 4.4.5. Харилцагч нь хуулийн этгээд, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч бол түүний нэрийн өмнөөс харилцах этгээд нь тийм эрхтэй эсэхийг нягталж уг этгээдийн овог нэр, эцэг/эхийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, баримт бичигтэй тулган шалгаж, хуулбарлан авах.
- 4.5. ХТМ үүрэг бүхий ажилтнууд нь харилцагчийг шинээр бүртгэх болон харилцагчийн хувийн хэргийг шинэчлэх тухай бүрд ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлж, байнгын хяналт тавьж ажиллах үүрэгтэй.
- 4.6. Хариуцсан салбар, нэгжийн захирлууд нь ХТМ үйл ажиллагаанд давхар хяналт тавьж, эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд КХА, ЭУГ-г мэдэгдэх, ХТМ нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэх захиралд мэдэгдэж шийдвэрлүүлнэ.
- 4.7. Харилцагч нь шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг өгөхөөс татгалзвал ББСБ-ын зүгээс үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.

#### ТАВ. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ НАРИЙВЧИЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 5.1. Харилцагчийн эрсдэлийн түвшин үнэлж, өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа хэрэгжүүлнэ. Өндөр эрсдэлтэй харилцагч гэж:
- 5.1.1. “улс төрд нөлөө бүхий этгээд /цаашид “УТНБЭ” гэх/, түүний хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой этгээд болон эдгээртэй адилтгах гадаад улсын болон олон улсын байгууллагын албан тушаалтныг;
- 5.1.2. харилцагчийн эцсийн өмчлөгч нь УТНБЭ бол;
- 5.1.3. МУТС /үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх/-тэй санхүүжүүлэх тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТС-тэй тэмцэх хяналтын тогтолцоо хангалтгүй гэж тодорхойлогдсон улсын иргэн, хуулийн этгээд;
- 5.1.4. МУТС-тэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэд гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээд;
- 5.1.5. “харилцагчийн эрсдэлийн түвшин үнэлэх аргачлал”-ын дагуу өндөр эрсдэлтэй гэж тогтоогдсон харилцагчийг хэлнэ.
- 5.2. КХА болон ХТМ үүрэг бүхий ажилтан нь харилцагчийг нарийвчлан таньж мэдэх зорилгоор иргэн, хуулийн этгээдийн талаарх хууль тогтоомжоор хориглоогүй нэмэлт мэдээллийг дараах тохиолдлуудад шаардах эрхтэй. Үүнд:
- 5.2.1. харилцагчийн талаарх мэдээллийн үнэн зөв эсэхэд эргэлзсэн;
- 5.2.2. ББСБ-тай харилцах зорилгыг тодорхойлохоор;
- 5.2.3. мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг тогтоохоор;
- 5.2.4. эцсийн өмчлөгчийг шалгаж тогтоон түүнийг таньж мэдэх;
- 5.2.5. УТНБЭ-ийг таньж мэдэх зорилгоор;
- 5.2.6. хориг арга хэмжээтэй холбогдуулан;
- 5.2.7. өндөр эрсдэлтэй харилцагчийг;

- 5.2.8. МУТС-тэй холбоотой гэж үзсэн аливаа тохиолдолд;
- 5.2.9. МУТС-тэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТС-тэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улс орон, нутаг дэвсгэрийн харьяат иргэн байх тохиолдлуудад нэмэлт мэдээлэл шаардана.
- 5.3. КХА болон ХТМ үүрэг бүхий ажилтнууд нь ХТМ нарийвчилсан үйл ажиллагааны хүрээнд МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 5.14 дэх заалтыг баримтлан дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 5.3.1. тухайн харилцагчийн эрхэлж буй ажил, бизнес, хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зориулалт, утга зэрэгтэй холбоотой нэмэлт мэдээллийг гаргуулж авах, боломжийн хэмжээнд эдгээр мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах;
  - 5.3.2. өндөр эрсдэлтэй харилцагч, сэжигтэй гүйлгээний талаар КХА болон ЭУГ-т мэдэгдэж, дүгнэлт гаргуулах;
  - 5.3.3. тухайн харилцагчтай бизнесийн харилцааг цаашид үргэлжлүүлэх эсэх талаар Гүйцэтгэх захирлын зөвшөөрөл авах;
  - 5.3.4. харилцагчийн данс, гүйлгээнд тавих хяналт давтамжийг нэмэгдүүлэх, хяналтын цар хүрээг өргөжүүлэн, харилцаж байгаа бусад этгээдийг хяналтад хамруулах, ХТМ зорилгоор харилцагчаас гаргуулан авсан мэдээллийг хянах;
  - 5.3.5. ХТМ нарийвчилсан үйл ажиллагаатай холбоотой бусад журам, зааврын шаардлагууд.
- 5.4. ХТМ нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан КХА болон ЭУГ-ын зүгээс харилцагчийн эрсдэлийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргах үүрэгтэй. Эрсдэлийн үнэлгээ, дүгнэлтийг Гүйцэтгэх захиралд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулна.
- 5.5. ХТМ үүрэг бүхий ажилтан нь өндөр эрсдэлтэй харилцагчийг ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээ авах бүрд холбогдох нэмэлт мэдээлэл, баримт бичгийг бүрдүүлж авах, харилцагчийн мэдээлэл, хувийн хэргийг шинэчлэх бүрд ХТМ нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлж, байнгын хяналт тавьж ажиллах үүрэгтэй.
- 5.6. ХТМ нарийвчилсан үйл ажиллагааны хэрэгжилтэд ЭУГ-ын зүгээс хяналт тавьж ажиллах бөгөөд Гүйцэтгэх захиралд тухай бүр тайлагнана.

#### ЗУРГАА. “УЛС ТӨРД НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭД”-ийг ТОДОРХОЙЛОХ

- 6.1. Тухайн хүний оршин суугаа хаягаар УТНБЭ-ийн төрөл, эрсдэлийн түвшинг тогтооно. Дотоод болон гадаад УТНБЭ-ийг Монгол банкны зааврын дагуу тодорхойлно. /хавсралт I/
- 6.2. ХТМ үүрэг бүхий ажилтан нь харилцагчийг “УТНБЭ” эсэх, эсвэл УТНБЭ-ийн хамаарал бүхий этгээд, нэгдмэл сонирхолтой этгээд эсэхийг ББСБ-аас зээл болон бусад төрлийн үйлчилгээ авах, гүйлгээ хийх тухай бүрд тодорхойлж ажиллана. Үүнд:
  - 6.2.1. харилцагчийн мэдээллийн үнэн зөв эсэхэд хяналт тавих;
  - 6.2.2. харилцагчийн мэдээллээс эргэлзээтэй зүйл, мөнгөний эх сурвалжийг тодруулах;
  - 6.2.3. ББСБ-ын дотоод бүртгэлийн системд харилцагчийн нэр, регистрийн дугаараар хайж, шалгах;
  - 6.2.4. харилцагчийн эцсийн өмчлөгч нь УТНБЭ эсэхийг тодорхойлох арга хэмжээ авч, бүртгэлийн программд шаардлагатай мэдээллийг оруулах;

- 6.2.5. харилцагч нь гадаадын иргэн бол журмын 3.1.2 дох заалтын дагуу мэдээллийг шалган холбогдох баримт бичгийг бүрдүүлнэ.
- 6.3. ХТМ үүрэг бүхий ажилтан нь УТНБЭ-ийг тодорхойлж, өндөр эрсдэлтэй гэж дүгнэх тохиолдолд КХА-нд мэдэгдэнэ. КХА-ны зүгээс харилцагчийг нарийвчлан таньж мэдэх арга хэмжээ авч, ЭУГ болон Гүйцэтгэх захиралд танилцуулан холбогдох арга хэмжээ авна. Шаардлагатай тохиолдолд бизнесийн харилцааг бүхэлд нь тусгайлан нягтлах болон сэжигтэй гүйлгээний тайлангаар СМА-д мэдээлнэ.
- 6.4. УТНБЭ-ийн гэр бүлийн гишүүд, хамаарал бүхий этгээд болон нэгдмэл сонирхолтой этгээдийг улс төрд нөлөө бүхий этгээдийн нэгэн адил ХТМ үйл ажиллагаанд хамруулна.
- 6.5. Гадаадын УТНБЭ-ийг харилцагчаар бүртгэх тохиолдолд КХА-нд мэдэгдэж, Гүйцэтгэх захиралд танилцуулан шийдвэрлэнэ.
- 6.6. Гадаадын УТНБЭ-тэй байгуулсан гэрээ сунгах, цуцлах, бизнесийн харилцаанд өөрчлөлт оруулах асуудлыг КХА-ны дүгнэлтийг үндэслэн, Гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.

#### ДОЛОО. ТУСГАЙ ХЯНАЛТ

- 7.1. ББСБ нь дараах гүйлгээнд тусгайлан хяналт тавих үүрэгтэй:
  - 7.1.1. огцом өөрчлөгдсөн их дүнтэй;
  - 7.1.2. эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй;
  - 7.1.3. УТНБЭ-ийн нэр дээр хийсэн;
  - 7.1.4. МУТС-тэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТС-тэй тэмцэх хяналтын тогтолцоо хангалтгүй гэж тодорхойлогдсон улсаар дамжуулан хийсэн.
- 7.2. Энэ хуулийн 7.1-д заасан гүйлгээний талаар ББСБ нь нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах, бизнесийн харилцаа, гүйлгээний зорилгыг боломжийн хүрээнд шалгаж, үр дүнг баримтжуулна.

#### НАЙМ. МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГ

- 8.1. ХТМ үүрэг бүхий ажилтан нь өндөр эрсдэлтэй харилцагч, сэжигтэй гүйлгээтэй холбоотой мэдээлэлд хяналт тавьж, илэрсэн тохиолдолд цаг тухайд нь шууд удирдлагад мэдэгдэх үүрэгтэй. Тухайлбал:
  - 8.1.1. харилцагчийн баримт мэдээлэл хуурамч, худал мэдээлэл өгсөн, эргэлзээтэй гэж үзсэн тохиолдолд;
  - 8.1.2. ажилтны шаардсан мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан, эсхүл бүрдүүлсэн баримт бичгийг эргэлзээтэй гэж үзсэн харилцагчийн талаарх мэдээллийг;
  - 8.1.3. харилцагч шинээр бүртгүүлэх, данс нээлгэх үед харилцагчийн эрсдэлийг үнэлж өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн харилцагчийн мэдээллийг;
  - 8.1.4. харилцагчийн нэр нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоол болон дотоод эрх бүхий байгууллагаас гаргасан Террорист гэж зарлагдсан этгээдийн нэрсийн жагсаалт болон бусад хориг арга хэмжээ дэх нэртэй тохирсон тохиолдолд гүйлгээг хийхгүй нэн даруй мэдээлэх;
  - 8.1.5. хуурамч, хүчингүй болсон мөнгөн тэмдэгт, гадаад валютаар гүйлгээ хийсэн болон

хийхээр оролдсон тохиолдол.

- 8.2. Салбар, нэгжийн захирал нь хариуцсан чиг үүргийн дагуу МУТС-тэй тэмцэх тухай хууль болон холбогдох журмын хэрэгжилтэд давхар хяналт тавьж, өндөр эрсдэлтэй харилцагч, сэжигтэй гүйлгээ илэрсэн даруйд зохистой арга хэмжээ авч, холбогдох мэдээллийг КХА болон ЭУГ-т хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэх захиралд мэдэгдэж, шийдвэрлүүлэх үүрэгтэй.
- 8.3. КХА нь батлагдсан маягт, холбогдох журмын дагуу тайлан, мэдээллийг Монгол банкны Санхүүгийн мэдээлийн албанд /цаашид СМА гэх/-д хүргүүлнэ. Үүнд:
- 8.3.1. 20 сая төгрөг буюу түүнээс дээш үнийн дүнтэй /түүнтэй тэнцэх гадаад валют/ бэлэн мөнгөний гүйлгээ, гадаад төлбөр тооцоо болон виртуал хөрөнгийн гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор, “Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан”;
- 8.3.2. хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг МУТС-тэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсвэл мэдсэн тохиолдолд 24 цагийн дотор /Сэжигтэй гүйлгээний батлагдсан маягт/;
- 8.4. КХА нь сэжигтэй гүйлгээ илэрсэн тохиолдолд, шаардлагатай хяналтыг хийж, баталгаажуулсны үндсэн дээр, дүн харгалзахгүйгээр батлагдсан маягтын дагуу холбогдох баримт, нэмэлт мэдээллийг хавсаргаж Монгол банкны СМА-д хүргүүлэх үүрэгтэй.

### ЕС. ХАРИЛЦАГЧИЙН ГҮЙЛГЭЭГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ

- 9.1. СМА-нд хүргүүлсэн мэдээллийн үндсэн дээр хийгдэхээр хүлээгдэж байгаа харилцагчийн гүйлгээг МУТС зорилготой гэж үзэх үндэслэлтэй тохиолдолд:
- 9.1.1. СМА-ны даргын шийдвэрээр тухайн гүйлгээг ажлын гурав хүртэл өдрийн хугацаагаар түдгэлзүүлэх,
- 9.1.2. шаардлагатай тохиолдолд шүүхийн шийдвэрээр уг хугацааг сунгах;
- 9.1.3. уг шийдвэрийг ББСБ-д 24 цагийн дотор мэдэгдэх;
- 9.1.4. тухайн гүйлгээг шалгасны үр дүнд МУТС зорилгогүй байсан гэдэг нь тогтоогдвол гүйлгээг түдгэлзүүлэх тухай шийдвэрийг цуцалж, ББСБ-д нэн даруй мэдэгдэх зэрэг арга хэмжээ авагдана.
- 9.2. ББСБ нь СМА-аас харилцагчийн гүйлгээг түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд эрх бүхий этгээдийн мэдэгдэл ирэх хүртэл гүйлгээг царцаана.
- 9.3. КХА нь холбогдох эрх бүхий байгууллагын мэдэгдэл, шийдвэрийг хүлээн авсан даруйд Гүйцэтгэх захиралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

### АРАВ. ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ

- 10.1. ББСБ нь МУТС-тэй тэмцэх тухай хууль, ҮОХЗДТ-тэй тэмцэх тухай хууль болон холбогдох журам, бусад зохицуулалтын дагуу Засгийн газраас ҮОХЗ дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой баталсан хүн, хуулийн этгээдийн эсрэг санхүүгийн зорилтот арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 10.2. ББСБ нь хориг арга хэмжээний жагсаалт болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн

- этгээд /цаашид “*жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд*” гэх/-тэй шууд, эсхүл шууд бусаар холбоотой аливаа харилцагч, гүйлгээ, гэрээ, хэлцэл, хөрөнгө, мөнгө байгаа эсэхийг шалгах үүрэгтэй.
- 10.3. Дараах хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлд данс нээх, гүйлгээ хийх, үйлчилгээ үзүүлэхийг хориглоно. Үүнд:
- 10.3.1. НУБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг жагсаалт;
- 10.3.2. дотоодын эрх бүхий байгууллагын баталсан жагсаалт /Засгийн газар/;
- 10.3.3. ББСБ-ын баталсан жагсаалт.
- 10.4. ББСБ нь жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, тэдгээрийн нэрийн өмнөөс шууд, эсхүл шууд бусад, эсхүл тэдгээрийн зааврын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн мөнгөн хөрөнгө, мөнгө байгаа гэж үзвэл холбогдох хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 10.5. Дээрх тохиолдолд КХА нь холбогдох хууль, журам, зохицуулалтад заасан аргачлалын дагуу Тагнуулын байгууллага болон СМА-нд тайлан, мэдээллийг 24 цагийн дотор хүргүүлэх үүрэгтэй.

#### АРВАН НЭГ. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- 11.1. ББСБ-ын эрх бүхий албан тушаалтан болон ажилтнууд нь СМА-нд холбогдох хууль, журмын дагуу сэжигтэй гүйлгээ, үйл ажиллагааны талаар мэдээлсэн, нэмэлт мэдээлэл гаргаж өгсөн, МУТС холбоотой шалгагдаж байгаа тухай аливаа хэлбэрээр харилцагчид өөрт нь болон бусад гуравдагч этгээдэд мэдээлэл дамжуулах, задруулахыг хориглоно.
- 11.2. Дээрх заалт нь ББСБ-ын удирдлага болон ажилтан хоорондын харилцаа, хуульчид, бусад эрх бүхий байгууллага, прокурорын байгууллагад мэдээлэл дамжуулах болон солилцох харилцаанд хамаарахгүй.
- 11.3. Мэдээллийн нууцлал:
- 11.3.1. ББСБ-ын ажилтан нь иргэн, хуулийн этгээдтэй бизнесийн харилцаа тогтоох буюу харилцагчаар бүртгэж санхүүгийн үйлчилгээг шударга, эрх тэгш хангаж, хууль болон энэхүү журамд зааснаас бусад тохиолдолд үйлчилгээ үзүүлэхээс татгалзахгүй бөгөөд бүртгэгдсэн харилцагчийн мэдээллийн нууцлалыг чанд сахина;
- 11.3.2. ББСБ нь Монгол Улсын МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 7.1 , 7.2 дах заалтын дагуу гүйлгээний мэдээллийг бэлтгэсэн, мэдээлэх гэж байгаа, мэдээлсэн, шилжүүлсэн талаарх гүйлгээний нууцлалыг алдагдахаас урьдчилан сэргийлж ажиллана;
- 11.3.3. сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний тайланг бэлтгэх, мэдээлэх, дансны гүйлгээнд тусгайлсан хяналт тавих зэрэг нь нууцлалын зэрэгтэй мэдээлэл байна.
- 11.4. ББСБ-ын удирдлага болон ажилтан нь СМА болон бусад эрх бүхий байгууллагад хууль, журамд заасны дагуу мэдээлэл өгснийг аж ахуй нэгж, бизнесийн болон хувь хүний нууцыг задруулсан гэж үзэхгүй бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

## АРВАН ХОЁР. ХАРИЛЦАГЧИЙН БАРИМТ МАТЕРИАЛЫН ХАДГАЛАЛТ

12.1. ББСБ нь харилцагчийн хийсэн гүйлгээ, данс болон харилцагчийн талаар олж авсан мэдээлэл, баримт бичгийг хуульд заасан хугацаанд хадгалах үүрэгтэй. Тухайлбал:

№	Баримтын төрөл	Хадгалах хугацаа
1	<ul style="list-style-type: none"> <li>Харилцагчийн данс нээх, бизнесийн харилцаа үүсгэхэд ашигласан бичиг баримт;</li> <li>ХТМ хүрээнд олж авсан бичиг баримтууд, биеийн байцаалтын хуулбар;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Данс хаагдсанаас эсхүл бизнесийн харилцаа дуусгавар болсноос хойш 5-аас доошгүй жил;</li> <li>Тохиолдлын чанартай гүйлгээ хийсэн бол гүйлгээ хийгдсэнээс хойш 5-аас доошгүй жил;</li> </ul>
2	<ul style="list-style-type: none"> <li>Харилцагчийн мэдээллийг нарийвчлан шалгах явцад олж авсан баримт, мэдээлэл;</li> <li>Харилцагчийн мэдээлэлд орсон өөрчлөлт, нэмэлт баримт, мэдээлэл, дансны мэдээлэл;</li> <li>МУТС эрсдэлийг тодорхойлоход ашигласан мэдээлэл, харилцагчийг таньж мэдэх, тусгайлан хяналтын дүгнэлт, сэжигтэй гүйлгээтэй холбоотой баримт, материал;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Харилцаа дуусгавар болсноос хойш 5-аас доошгүй жил.</li> </ul>
3	<ul style="list-style-type: none"> <li>Бэлэн болон бэлэн бус гүйлгээний баримтууд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Гүйлгээ хийгдсэнээс хойш 5-аас доошгүй жил.</li> </ul>

12.2. ББСБ нь харилцагчийн мэдээлэл, баримт бичгийг “Албан хэрэг хөтлөлтийн журам”-ын дагуу хадгалж, шаардлагатай тохиолдолд эрх бүхий этгээд, хууль сахиулах байгууллагын хүсэлтээр шуурхай гаргаж өгөхөд бэлэн байхаар зохион байгуулна.

## АРВАН ГУРАВ. ХУУЛЬ ТОГТООМЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ҮҮРЭГ

13.1. ББСБ-ын холбогдох нэгжүүд нь МУТС-ээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагаанд дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

13.2. ЭУГ, Комплаенс хариуцсан ажилтан:

13.2.1. МУТС-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр батлагдсан хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

13.2.2. дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж тайлагнах, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх;

13.2.3. МУТС-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх журам, зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгуй болгох;

13.2.4. ББСБ-ын нийт ажилтнуудад МУТС-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

13.2.5. харилцагчийн гүйлгээнд хяналт тавих, нэгжээс ирүүлсэн сэжигтэй гүйлгээнд дүн шинжилгээ хийх, сэжигтэй гүйлгээг СМА-д мэдээлэх;

13.2.6. харилцагчийн эрсдэлийн үнэлгээг хийх, өндөр эрсдэлтэй харилцагч эсвэл

- түүний гүйлгээнд тусгай хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авах;
- 13.2.7. эрх бүхий байгууллагын хяналт, шалгалт, аудитын үр дүн, өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх.
- 13.3. Зээлийн удирдлагын газар, /салбар/:
- 13.3.1. ББСБ-аас бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчид хүргэхдээ МУТС-тэй тэмцэх хууль, холбогдох журмыг баримтлан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 13.3.1.1. ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- 13.3.1.2. харилцагчийн мэдээллийг программд үнэн зөв, бүрэн гүйцэд оруулах;
- 13.3.1.3. хувийн хэргийн бүрдлийг хангах;
- 13.3.1.4. холбогдох журмын дагуу данс нээх, хаах, харилцагчийн хувийн хэргийг хадгалах үйл ажиллагаанд шат дараалсан хяналтыг хэрэгжүүлэх.
- 13.3.2. итгэлцлийн эх үүсвэр татах, зээл олгох үйл ажиллагаанд МУТС эрсдэлийг бууруулах зорилгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 13.3.2.1. харилцагчийн мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлох;
- 13.3.2.2. хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагыг шалгах;
- 13.3.2.3. эцсийн өмчлөлийг тодорхойлох;
- 13.3.2.4. хууль бусаар олсон мөнгөн хөрөнгө болон зээлийн зарцуулалтыг МУТС үйл ажиллагаанд ашиглахаас сэргийлж ажиллах;
- 13.3.3. ЗУГ нь МУТС эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 13.3.3.1. салбаруудын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавих;
- 13.3.3.2. ажилтнуудыг чадавхжуулах ажлыг ЭУГ-тай хамтран зохион байгуулах;
- 13.3.4. СЗХ, СМА болон бусад эрх бүхий байгууллагын хууль ёсны шаардлагын дагуу аудит, хянан шалгалтад шаардлагатай харилцагч, гүйлгээтэй холбоотой мэдээлэл, баримт бичгийг үнэн зөв, цаг тухайд нь нэгтгэн гаргаж өгөх ажлыг хариуцан гүйцэтгэх.
- 13.4. Маркетингийн мэргэжилтэн:
- 13.4.1. МУТС-тэй тэмцэх тухай хуульд заасны дагуу шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх судалгаанд бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх арга, хэлбэр, газарзүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэлийг тооцоолох;
- 13.4.2. эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЭУГ-тай хамтран ажиллах, дүгнэлт гаргуулах;
- 13.4.3. ББСБ-д мөрдөгдөж байгаа бүтээгдэхүүн үйлчилгээнд МУТС-тэй холбоотой эрсдэлийг тооцоолж, эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах санал боловсруулах, хяналт тавих;
- 13.4.4. ХТМ болон хяналтыг сайжруулах зорилгоор программ хангамжийг хөгжүүлэх, техник технологийн дэвшил, мэдээллийн бааз авч ашиглах.
- 13.5. Дотоод аудит хариуцсан нэгж:
- 13.5.1. ББСБ-ын салбар, нэгжийн үйл ажиллагаанд газар дээрх болон зайны аудит хийх, холбогдох журам, зааврын дагуу эрсдэлийг үнэлэх;

13.5.2. харилцагчийн мэдээллийг шинэчилж байгаад хяналт тавих.

### АРВАН ДӨРӨВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

- 14.1. Нийт ажилтнууд энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллах бөгөөд ЭУГ-ын зүгээс хяналт тавьж, Гүйцэтгэх захирал удирдлагаар хангаж ажиллана.
- 14.2. Дотоод аудитын нэгж нь чиг үүргийн дагуу журмын хэрэгжилтэд давхар хяналт тавих, үйл ажиллагааны аудит хийх зэргээр дотоод хяналтыг хэрэгжүүлж, үр дүнг ТУЗ-д тайлагнана.
- 14.3. Нийт ажилтнууд нь журмын хэрэгжилттэй холбогдуулан эрх бүхий ажилтны шаардсан мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгөх, хэрэгжилтийг хангуулах хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 14.4. ББСБ-ын ажилтны өгсөн мэдээлэл нь МУТС зорилгогүй байсныг тогтоосон нь тухайн мэдээлэл өгсөн ажилтныг хуулийн хариуцлагад татах үндэслэл болохгүй.
- 14.5. Тодорхой гүйлгээг хууль, журмын дагуу түдгэлзүүлснээс иргэн, аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд гэм хор учирсан нь ББСБ, түүний удирдлага, ажилтныг хариуцлагад татах үндэслэл болохгүй.
- 14.6. МУТС-ээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхтэй холбогдуулан нийт ажилтнуудад дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:
  - 14.6.1. нэргүй, дугаарласан, кодолсон, эсхүл хуурамч нэрээр ББСБ-ын үйлчилгээ үзүүлэх;
  - 14.6.2. дараах тохиолдолд ХТМ хялбаршуулсан үйл ажиллагаанд хамруулахыг хориглоно:
    - 14.6.2.1. харилцагч, эсвэл түүний гүйлгээг МУТС-тэй холбоотой гэж үзсэн;
    - 14.6.2.2. СМА, бусад эрх бүхий байгууллагаас өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон бизнес, улс оронтой холбоотой этгээд.
  - 14.6.3. хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлд гүйлгээ хийх, шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэх;
  - 14.6.4. ББСБ-ын шаардсан мэдээлэл, баримт бичгийг өгөхөөс татгалзсан харилцагчид үйлчилгээ үзүүлэх.
- 14.7. ХТМ үүрэг бүхий ажилтан болон хяналт тавих чиг үүрэг бүхий ажилтан хариуцсан ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн нь “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно. Тухайлбал:
  - 14.7.1. харилцагчийн мэдээллийг дутуу, алдаатай бүртгэх;
  - 14.7.2. хариуцсан ажилтны буруугаас харилцагчийн гүйлгээ саатах, харилцагчийн мөнгөн хөрөнгө эрсдэх;
  - 14.7.3. харилцагчийн хувийн хэргийг дутуу бүрдүүлэх;
  - 14.7.4. дутуу баримтын бүрдлээр зээл болон санхүүгийн гүйлгээ хийх;
  - 14.7.5. ажилтны хариуцлагагүйгээс давхар болон дараалсан хяналт алдагдах.
- 14.8. ББСБ-ын ажилтнууд нь МУТС-тэй тэмцэх хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг

хангах хүрээнд ХТМ, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх, хориг арга хэмжээг хэрэгжүүлэх болон дотоод хяналтын чиг үүргийг орхигдуулж, ажилдаа хариуцлагагүй хандснаас байгууллага болон харилцагчид эрсдэл учирсан тохиолдолд холбогдох хууль, "Хөдөлмөрийн дотоод журам"-ын дагуу хариуцлага хүлээлгэх болно.

"БҮРЭНФИНАНС ББСБ" ХХК

\_\_\_\_\_ ооо \_\_\_\_\_

МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмын  
Хавсралт I

Монгол банкны зааврын дагуу дотоод болон гадаад УТНБЭ-ийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. Дараах хүмүүсийг дотоодын УТНБЭ гэж үзнэ. Үүнд:
  - 1.1. Монгол Улсын ерөнхийлөгч, ерөнхий сайд, сайд нар;
  - 1.2. Дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, гүйцэтгэх болон хэрэгжүүлэгч агентлагийн дарга, дэд дарга нар;
  - 1.3. УИХ-ын гишүүд;
  - 1.4. Монголбанкны ерөнхийлөгч болон захирлуудын зөвлөлийн гишүүд, Хяналтын зөвлөлийн гишүүд; Санхүүгийн зохицуулах хорооны дарга, удирдлага;
  - 1.5. Үндсэн хуулийн цэц, Дээд болон бусад шүүхийн дарга, гишүүд, шүүгч нар; 3.2.6 Ерөнхий прокурор, түүний орлогчид;
  - 1.6. Тагнуулын ерөнхий газрын дарга, түүний орлогчид;
  - 1.7. Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд нар;
  - 1.8. Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Хуурай замын зэвсэгт хүчин болон Агаарын цэргийн командлагчид, тэдгээрийн орлогчид;
  - 1.9. Орон нутгийн гүйцэтгэх засаглалын, прокурорын, тагнуулын байгууллагын дарга нар, давж заалдах шатны болон дүүргийн шүүхийн ерөнхий шүүгч болон шүүгч нар;
  - 1.10. Төрийн өмчийн, төсвийн байгууллагуудын, дүрмийн сангийн 50-с дээш хувийг төр эзэмшиж буй эдийн засгийн түншлэлийн захиргаа, удирдлага, хяналт шалгалтын чиг үүрэг бүхий нэгжүүдийн дарга нар;
  - 1.11. Улс төрийн намуудын удирдах зөвлөлийн дарга, намын төв аппаратын гишүүд;
  - 1.12. Засгийн газрын агентлагийн дарга;
  - 1.13. Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны бүрэн эзэмшилд буй компаний захирлууд.
2. Дараах иргэдийг олон улсын байгууллагын УТНБЭ гэж үзнэ. Үүнд:
  - 2.1. Сүүлийн хэдэн жил олон улсын байгууллагад удирдах албан тушаал хашиж байсан/байгаа (тухайлбал, захирал, зөвлөлийн тэргүүн, тэдгээрийн орлогч нар) хүн;
  - 2.2. Удирдлагын бусад чиг үүргийг дээд түвшинд хэрэгжүүлж байгаа/байсан (ялангуяа олон улсын эсвэл засгийн газар хоорондын байгууллагад) хүн;
  - 2.3. Олон улсын парламентын ассамблейн гишүүд;
  - 2.4. Олон улсын шүүхийн шүүгчид болон удирдах албан тушаалтнууд.
3. "Гэр бүлийн гишүүд" - УТНБЭ-тэй шууд эсвэл гэр бүлийн харилцаагаар нягт холбоотой хүмүүс. Үүнд:
  - 3.1. эхнэр, нөхөр болон хамтран амьдрагч;
  - 3.2. хүүхэд (үрчилж авсан, дагавар хүүхэд мөн багтана);
  - 3.3. төрсөн болон хойд эцэг, эх;



- 3.4. эхнэр, нөхөр, хамтран амьдрагчийн эцэг, эх;
- 3.5. төрсөн болон хойд эцэг, эхийн хүүхэд.

“БҮРЭНФИНАНС ББСБ” ХХК